

ГУРВАН ОРНЫ ЭРДЭМТДИЙН ФОРУМ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль хамтран “Ногоон хөгжил - XXI зууны гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл” сэдэвт Монгол, Орос, Хятад гурван орны эрдэмтдийн IV форумыг Монгол Улсын Ерөнхий сайд Н. Алтанхуягийн ивээл дор Төрийн ордонд 2013 оны 10-р сарын 5-ны өдөр зохион байгуулав.

Монгол, Орос, Хятад 3 улсын эрдэмтдийн анхдугаар форумыг ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн санаачилгаар анх 2008 онд Улаанбаатар хотноо “Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа” сэдвийн дор Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулж байв. Уг форумыг гурван тал ээлжлэн хүлээн авч зохион байгуулахаар тохирсоны дагуу II форумыг БНХАУ-ын Нийгмийн Шинжлэх ухааны академийн Ази-Номхон далайн хүрээлэн 2009 онд “Хятад, Монгол, Орос: энх тайван, хөгжил, хамтын ажиллагаа” сэдвийн дор Бээжин хотноо, III форумыг ОХУ-ын ШУА-ийн Дорнодахин судлалын хүрээлэн “Орос, Хятад, Монгол орчин үеийн шинэ сорилтыг хамтдаа даван туулах нь” сэдвийн дор 2012 онд Москва хотноо тус тус амжилттай зохион байгуулсан билээ.

Энэ удаагийн форумын гол зорилго бол хөрш орнууд хоёр болон гурван талт харилцаа хамтын ажиллагаандаа дэлхийн нийтийн хөгжлийн гол чиг хандлага болсон Ногоон хөгжлийн үзэл ойлголт, зарчмыг мөрдлөг болгох зайлшгүй шаардлага үндэслэлийг хамтран хэлэлцэж, хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэхэд оршсон байна.

Монгол улс нь хоёр хүчирхэг гүрний дунд оршдог, эдийн засгийн хувьд хоёр хөршөөсөө ихээхэн хамааралтай байдгийн хувьд Ногоон хөгжлийн үзэл баримтлалаа боловсруулан хэрэгжүүлэхдээ хоёр хөрштэйгөө нягт хамтран ажиллах, тэдгээр орны хүчин зүйлсийг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай болно.

Хурлын нээлтэнд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин нар баяр хүргэж үг хэлж, хөрш хоёр орноос тус улсад суугаа ЭСЯ-ны дипломатууд, хэвлэл мэдээллийн төлөөлөл байлцлаа.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Монгол, Орос, Хятад гурван орны эрдэмтдийн IV форумын үйл ажиллагаанд амжилт хүссэн мэндчилгээ ирүүлж, гадаадын зочдыг хүлээн авч

уулзсан бөгөөд Ногоон хөгжлийн олон талт асуудлаар хөрш орнуудын эрдэмтэдтэй санал бодлоо солилцон тухайн орон бүрд гарч буй ахиц дэвшил, ололт амжилт, тулгарч буй хүндрэл бэрхшээл, цаашдын хамтын ажиллагааны боломжийн талаар өргөн хүрээнд хэлэлцсэн тус эрдэм шинжилгээний форумд ОХУ, БНХАУ-аас 20, Монгол Улсын 50 гаруй эрдэмтэн судлаачид 20 орчим илтгэл хэлэлцсэн байна. Монгол-Орос-Хятадын стратегийн түншлэл ба ногоон хөгжил, Төмөр зам ба экологийн аюулгүй байдал, Хөрсний элэгдэл, Сэргээгдэх эрчим хүч, Бүс нутгийн хамтын ажиллагаа гэх мэт олон сонирхолтой илтгэлийг тавьж хэлэлцүүлэв.

Форумд оролцогчид нэгдсэн хуралдаанаас гадна Төв аймгийн Засаг даргын Тамгын газарт зочлон орон нутгийн бүтээн байгуулалт, малчин өрхийн амьдралтай танилцан, Клин Энержи ХХК-ийн Төв аймгийн нутаг дэвсгэрт байрлах Салхит ууланд байгуулж, ашиглалтанд оруулсан Монголын хамгийн том сэргээгдэх эрчим хүчний салхин цахилгаан станцын үйл ажиллагааг үзэж сонирхсон байна.

Мэдээ бэлтгэсэн Д.Золбоо
/ОУСХ-гийн ЭША/